

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТӨСӨВТ ӨРТӨГ, ҮНЭ БҮРДЛИЙН
ХЯНАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Д.ЧИНБАТЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Нэгжийн нэр: Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1.2.4.7. Хууль тогтоомж, сайдын шийдвэр, салбарын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, нэгдсэн тайлан гаргах, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;					
1.	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны баримт материалыг архивлах	60	10	70	
Зорилт 2.5.5.1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж, хэрэгжүүлэх, дүгнэх, нэгдсэн удирдлагаар хангана.					
1.	Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг болон төсөл хөтөлбөрийн төсөлд санал өгөх	60	10	70	
2.	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын дагуу ажиллах;	54	10	64	
Зорилт 2.5.5.2. Хот байгуулалт, барилгын материал, өргөх байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, инженер геологи, барилга байгууламж, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын явцад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, техникийн чанар аюулгүй байдлыг хангуулна.					
1.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 объектод төлөвлөгөөт шалгалт хийх; АХ-2050-2.5.11	42	5	47	
2.	Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар,	51	10	61	

	техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх; УХТЖҮЧ-9.3.2, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4				
3.	Соёл урлаг боловсролын байгууллагын барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх;	48	10	58	
4.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	57	10	67	
5.	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	54	10	64	
6.	Барилга байгууламжийн чанар аюулгүй байдал, өргөх байгууламжийн техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор улсын хэмжээнд аян зохион байгуулах тушаал боловсруулж батлуулах, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэх, барилга чанар, аюулгүй байдлыг хангуулах	48	10	58	
7.	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах;	60	10	70	
Салбарын сургалт зохион байгуулах ажлын хүрээнд					
1.	Салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах	60	10	70	
2.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх.	60	10	70	
Дундаж оноо:				64.08	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Барилгын төсөвчний сургалтад хамрагдах	100%	15	
2.	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	100%	15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	5	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	5	
5.	Ажлын цаг ашиглалт	5	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		5.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	
1.	Хандлага, ёс зүй	2
2.	Багаар ажиллах	7.9
3.	Харилцаа	7.9
Дундаж оноо		7.9

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгаавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	64.08
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	5.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.9
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо) 91.08
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)



/Б.НАЙРАМДАЛ/
(албан хаагчийн нэр)

2025.12.09 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

СХШУДАГ-ын шинжээч
(албан тушаал)

(гарын үсэг)

Төрийн жинхэнэ албан хаагч:

/Д.ЧИНБАТ/
(албан хаагчийн нэр)

2025.12.09 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын газрын
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
(албан тушаал)

(гарын үсэг)

/Б.БАТ-ЭРДЭНЭ/
(албан хаагчийн нэр)

2025.12. (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТЗУГ-ын ахлах шинжээчийн
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
(албан тушаал)

(гарын үсэг)

/Л.ЯНЖМАА/
(албан хаагчийн нэр)

2025.12.(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

ТНБД-ын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)



/М.БАЯРАА/
(албан хаагчийн нэр)

2025.12. (огноо)

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТӨСӨВТ
ӨРТӨГ, ҮНЭ БҮРДЛИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д. ЧИНБАТЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт /	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт хувь
0	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.2.4.7. Хууль тогтоомж, сайдын шийдвэр, салбарын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, нэгдсэн тайлан гаргах, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;							
6.1.9	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны баримт материалыг архивлах	Баримт материалуудыг төрөлжүүлэн архивлаж, архивт хүлээлгэн өгсөн байна.	-	Баримт материалуудыг төрөлжүүлэн архивлаж, архивт хүлээлгэн өгсөн байна.	Салбарын хяналтын газрын албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан 2 ботийг архивт хүлээлгэн өгөв.	2025.01.25	100%
Зорилт 2.5.5.1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж, хэрэгжүүлэх, дүгнэх, нэгдсэн удирдлагаар хангана.							
6.5.5	Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, нормативын баримт бичиг болон төсөл хөтөлбөрийн төсөлд санал өгөх	-Хууль-1 -Норм нормативын баримт бичиг-1	-	-Хууль-1 -Норм нормативын баримт бичиг-1	1. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд 10 зүйл бүхий санал боловсруулан СХОСБЗГ-т хүргүүлсэн. 2. ХББОСЯ-ны ХДЖ-ын төсөлд 5 санал өгсөн. 3. Барилга байгууламжийн нормативын сангийн журмын төсөлд 3 санал өгсөн. 4. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүчингүй болсонд тооцсон зарим норм, нормативын баримт бичиг Барилгын хөгжлийн төвөөс гаргасан хүчин төгөлдөр баримт бичгийн жагсаалтад бүртгэлтэй байгаа зөрчлийг арилгах тухай 08/4574 дугаар албан бичгийг БХТ-д хүргүүлсэн.	2025.01.15 2025.12.08	100%

6.5.7.	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын дагуу ажиллах;	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын хувь	-	7	<p>1. Үндэсний аудитын газраас хийгдэж буй "Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн" аудитын хүрээнд ирүүлсэн хавсралт хүснэгтийн Салбарын хяналтын чиг үүрэгт хамаарах хэсгийг боловсруулж, 2025.05.05-ны өдрийн 11/1135 дугаартай дотоод албан бичгээр СХОГ-т хүргүүлэв.</p> <p>2. Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланд дурдсан асуудлын талаар тус газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээллийг нэгтгэн боловсруулж, 2025.05.05-ны өдрийн 11/1134 дугаартай дотоод албан бичгээр ХШҮДАГ-т хүргүүлэв.</p> <p>3. Нийслэлийн засаг даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/153 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн хуралд суув. Хурлаас Нийслэлийн боловсролын газар ачаалал хэтэрсэн 14 ЕБС-ийн барилгыг 4 давхар болгох боломжийг судалж, боломжтой сургуулийн жагсаалтыг ХББОСЯ-д хүргүүлэх, ХББОСЯ хууль тогтоомжид заасны дагуу холбогдох мэргэжлийн болон шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, Энэ ондоо багтаан ЕБС-ийн барилгыг 4 давхар, цэцэрлэгийн барилгыг 3 давхар байхаар норм, дүрэмдээ өөрчлөлт оруулах боломжийг судалж, хариу өгөх гэсэн чиглэл өгснийг удирдлагад танилцуулав.</p> <p>4. СХГ-ын 2026 оны үйл ажиллагааны төсвийн саналыг СХОГ-т 2025.05.28-ны өдрийн 11/1177 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>5. ХББОСЯ-ны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд СХГ-ын стратеги төлөвлөгөөний 2 зорилт, 5 арга хэмжээний</p>	2025.01.15 2025.12.08	100%
--------	---	---	---	---	--	--------------------------	------

төслийг боловсруулж, ажлын хэсэгт хүргүүлсэн.

6. Сайдын 2025 оны 209 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, Алтанбулаг хийлийн боомтын будгийн болон химийн лабораторийн тоног төхөөрөмж, Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах авах ажиллагаа, гэрээний нөхцөлүүдэд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулав.

7. Үндэсний аудитын газраас ирүүлсэн “Аудитын шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, биелэлтийг ирүүлэх тухай” албан бичгийн дагуу тус яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 02/3918 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

8. Сайдын 2025 оны А/152 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, сонгогдсон аудитын компаниудтай байгуулах гэрээний төслийг боловсруулж, ажлын хэсэгт хүргүүлэв.

9. ОБЕГ-ын 2025.11.03-ны өдрийн “Биелэлт ирүүлэх тухай” 07/3003 дугаартай албан бичгийн дагуу “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт”-ийн СХШҮДАГ-т хамаарах тайланг гаргаж Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газарт хүргүүлэв.

10. Сайдын 2025 оны 256 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, яамны төсвийн шууд захирагчийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна.

Зорилт 2.5.5.2. Хот байгуулалт, барилгын материал, өргөх байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, инженер геологи, барилга байгууламж, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын явцад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, техникийн чанар аюулгүй байдлыг хангуулна.

6.6.1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 объектод төлөвлөгөөт шалгалт хийх; АХ-2050- 2.5.11	-Шалгалт хийсэн объектын тоо	-	3	Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 2 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. 1. Солонго 1, 2 төслийн хүрээнд хэрэгжиж буй 63 блок барилгад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.05.12-ны өдрийн 02-00-01/003/87 дугаар албан шаардлагыг ТОСК, зохиогч, гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн. 2. Бүгд найрамдах Польш Улсын хөнгөлөлтэй зээлээр хэрэгжиж буй Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудад хэрэгжиж буй цэвэрлэх байгууламжид хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.05.29-ний өдрийн 02-00-03/001/94 дугаартай албан шаардлагыг төслийн нэгжид хүргүүлсэн.	2025.01.15 2025.12.08	67%
6.6.2	Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх; УХТЖҮЧ-9.3.2, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4	-Шалгалт хийсэн объектын тоо -Хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	- -	- 1 - 85	Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/94 дүгээр тушаалын дагуу Хэнтий аймаг, Хэрлэн сумын 6-р багт Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 50 хүн/цаг хүчин чадалтай ЗС ангиллын нисэх онгоцны буудлын барилгыг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, 2 заалт бүхий үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврийн биелэлт 100 хувь. ХББОС-ын сайдын 2025 оны 97 дугаар тушаалын дагуу тус нисэх буудлын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, санал дүгнэлтийг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлэв.	2025.01.15 2025.12.08	100%
6.6.3.	Соёл урлаг боловсролын	Шалгалт хийсэн объектын тоо	-	1	Боловсролын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар	2025.02.12 2025.02.26	100%

	байгууллагын барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх;				сарын 12-ны өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 03-00/04 дугаартай удирдамжийн хүрээнд СХД-т байрлах ерөнхий боловсролын “Өнөр” сургуулийн хичээлийн 3 дугаар байр нь сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажиллаж, барилгын дүгнэлтийг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлэв.		
6.6.7	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон өргөдөл гомдол, ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	-	100%	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 10 төлөвлөгөөт бус шалгалт хийж, 5 дүгнэлт гаргаж, 1 зөрчлийн хэрэг үүсгэж, эрх бүхий албан тушаалтны 4 даалгавар хүргүүлж, 45 сая төгрөгийн торгууль шийтгэвэр оногдуулсан. 1. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораториос 2025.01.17-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02-00/09 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж дүгнэлтийг 11/728 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2. Монголын нотариатчидын танхим НҮТББ-аас ирүүлсэн хүсэлт, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны “Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” 02-00/18 дугаартай удирдамжийн дагуу Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Архивын ерөнхий газартай хамтран Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Тасганы овоо, 15150, Их тойруу гудамж, 25 тоот хаягт байршилтай оффисын барилгын 15 давхрын төлөвлөлт, ашиглалтын төлөв байдал болон архивын баримт хадгалж болох эсэхэд хяналт	2025.01.15 2025.12.08	100%

шалгалтыг хийж, дүгнэлтийг 11/1013 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.

3. Иргэн Ч.Мөнхдөлөөс ирүүлсэн гомдлын дагуу 2502000266 дугаартай зөрчлийн хэрэг нээн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулаад, холбогдогч таван компанид 45,000,000 (дөчин таван сая) төгрөгийн торгууль оногдуулж, дөрвөн компанид зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авхуулах эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, 11/2151 дугаартай албан бичгээр гомдол гаргагч иргэнд хариу хүргүүлэв.

4. Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсээс 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 30ea-2/1979 дугаартай албан бичгээр ирүүлсэн Ө-2962 дугаартай гомдолд хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулаад “Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах тухай” эрх бүхий албан тушаалтны тогтоолыг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэв.

5. Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын гуравдугаар хэлтсээс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 30д/2457 дугаартай албан бичгээр ирүүлсэн 3500 дугаартай гомдолд хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулаад “Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах тухай” эрх бүхий албан тушаалтны тогтоолыг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэв.

6. Иргэн З.Амгалангаас ирүүлсэн гомдлыг судалж үзээд барилгын чанар стандарт хангасан эсэх асуудал НХШГ-т шалгагдаж байх тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасны

					<p>дагуу дээрх газар шилжүүлж, эрүүл ахуй, аюулгүй байдлын хувьд амьдран суух боломжтой эсэхийг шалган тогтоолгох хүсэлтийг чиг үүргийн дагуу Нийслэлийн эрүүл мэндийн газарт шилжүүлснийг иргэн 3.Амгаланд 11/2197, 11/2198 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p> <p>7. Иргэн Ш.Шагдарсүрэнгээс гаргасан гомдлыг судалж үзээд харьяаллын дагуу 2025.03.19-ний өдрийн “Гомдол уламжлах тухай” 11/934 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн засаг даргын тамгын газарт тус тус хүргүүлэв.</p> <p>8. Иргэн Н.Бадрал, Н.Оргил нараас ирүүлсэн гомдол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 02-00/34 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж Эрх бүхий албан тушаалтны 02-00-01/005/88 дугаартай дүгнэлт гаргаж хүргүүлэв.</p> <p>9. “Монгол химикал” ХХК-аас ирүүлсэн гомдлын дагуу Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Хилчний гудамжны 66/2 тоот хаягт байрлах “Монгол химикал” ХХК-ийн “Үйлдвэр, үйлчилгээний барилга”-д шалгалт хийж, дүгнэлтийг удирдлагад танилцуулав.</p> <p>10. Иргэн Б.Мөнхдэлгэрээс ирүүлсэн гомдол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 00-02/51 дугаартай удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Эс энд Ви Юу” ХХК-ийн захиалгаар баригдаж буй үйлчилгээтэй орон сууцны барилгад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байна.</p>		
6.6.8	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн тоо	-	1	Зөрчлийн 2502000266 дугаартай хэрэгт гүйцэтгэлийн шалгалт хийж, холбогдогч “Эбо даймонд” ХХК, “Эринзууны суварга” ХХК, “Лонсинмонголиа” ХХК, “Ихэр хүслэн”	2025.10.27 2025.11.11	100%

	албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх				ХХК нарт зөрчлийн үр дагаврыг арилгуулах ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх эрх бүхий албан тушаалтны 01 дугаартай хүсэлт, "Эбо даймонд" ХХК, "Эринзууны суварга" ХХК, "Инстал наран констракшн" ХХК нарт оногдуулсан торгох шийтгэлийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн тооцож, үндсэн торгуулийн төлбөр 25,000,000 (хорин таван сая) төгрөг, нэмэгдүүлсэн төлбөр 12,500,000 (арван хоёр сая таван зуун мянга) төгрөг, нийт 37,500,000 (гучин долоон сая таван зуун мянга) төгрөгийн төлбөрийг тус тус шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулах эрх бүхий албан тушаалтны 02 дугаартай хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 08/4161 дугаартай албан бичгээр Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлэв.		
6.6.12.	Барилга байгууламжийн чанар аюулгүй байдал, өргөх байгууламжийн техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор улсын хэмжээнд аян зохион байгуулах тушаал боловсруулж батлуулах, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэх, барилга чанар, аюулгүй байдлыг хангуулах	-Тушаал -2; -Барилга байгууламж, өргөх байгууламжийн аюулгүй байдлыг хангуулсан тоо.	-		ХББОСС, ГБХНХС-ын хамтарсан 100/А101 дугаар тушаалыг батлуулж, аймаг, нийслэлд хүргүүлсэн. "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" 2 сарын аяны хүрээнд улсын хэмжээнд 717 объектод хяналт шалгалтыг хийж, 633 зөрчил илрүүлэн 308 зөрчлийг арилгуулж, 98 албан шаардлага, 7 акт, 228 дүгнэлт, 45 зөвлөмжийг гаргаж, 40 иргэн, хуулийн этгээдэд 151.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны даалгаврыг өгсөн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 83 дугаартай тушаалыг батлуулж, аймаг, нийслэлд хүргүүлсэн. Цамхагт краны аюулгүй байдлыг хангах аяны хүрээнд улсын хэмжээнд 45 байгууллагын 58 цамхагт краны техникийн аюулгүй байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 45 дүгнэлт гаргасан, 58 аж ахуйн нэгжид	2025.04.21 2025.06.21	100%

					албан даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан, ашиглалтын шаардлага хангахгүй 2 краныг буулгасан, 6 ААН-д 16.000.000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.		
6.6.13.	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах;	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу авсан арга хэмжээ	-	Зөрчлийн талаарх гомдол мэдээллэлд хуулийн дагуу арга хэмжээ авсан байна.	Иргэдээс ирүүлсэн гомдол болон харьяаллын дагуу шилжүүлсэн зөрчлийн талаарх 5 гомдол мэдээллийг хүлээн авч, нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, 2 гомдлыг хүлээн авахаас татгалзаж, 2 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлэн, 1 гомдолд зөрчлийн хэрэг нээж, холбогдогч 5 байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авч шийдвэрлэсэн.	2025.01.15 2025.12.08	100%
Салбарын сургалт зохион байгуулах ажлын хүрээнд							
6.6.14.	Салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтыгн тоо	-	1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, салбарын төрөөс баримтлах бодлого, анхаарах асуудал, хяналт шалгалтын ажлын гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангуулах, тулгамдаж байгаа асуудлаар санал солилцох, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр цахимаар, 2025 оны 02 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд танхимаар зохион байгууллаа. Сургалтад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн улсын (ахлах) байцаагч болон албан хаагчид, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналт, барилга байгууламжийн техникийн хяналт, өргөх байгууламжийн хяналтын нийт 62 улсын (ахлах) байцаагч хамрагдсан.	2025.02.10 2025.02.15	100%


6.6.15.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх.	1.Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь 2.Архивт хүлээлгэн өгсөн архивын нэгж.	-	1. 90% 2. Тухай бүр	Тайлант хугацаанд 29 хариутай албан бичиг, 10 өргөдөл хүлээн авч, 27 албан бичиг, 9 өргөдлийн хариуг өгсөн. Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийг тухай бүр архивт хүлээлгэн өгсөн.	2025.01.15 2025.12.08	100%
---------	--	---	---	------------------------	---	--------------------------	------

Хоёр Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ биелэлт

"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Барилгын төсөвчний сургалтад хамрагдах	Барилгын төсөвчний сургалтад хамрагдаж төгссөн байна	-	Барилгын төсөвчний сургалтад хамрагдаж төгссөн байна	Барилгын хөгжлийн төвд 2025 оны 02 дугаар сарын 17-ноос 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Төсөвчний анхан шат"-ны чадавхжуулах сургалтад суралцаж төгсөн АТ-25-3279 дугаарын гэрчилгээ авсан.	2025.02.17 2025.02.24	100%
2.	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна.	-	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна.	ХББОСЯ, Удирдлагын академийн хооронд байгуулсан УА/ТАС-297 дугаартай "Захиалгат сургалт явуулах тухай" гэрээний дагуу Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж байна.	2025.09.17 2025.12.08	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ШИНЖЭЭЧ, БАРИЛГЫН
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
(Албан тушаал)


.....
(Нэр, гарын үсэг)

/Д.ЧИНБАТ/

(Огноо)